



**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

┌ Эрүүл мэндийн төвийн цахилгаан шатны
ус тусгаарлалтын ажилд хөрөнгө гаргах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвд шинээр 2 ширхэг цахилгаан шат угсрах явцад лифтийн хонгилд хөрсний ус шүүрч гарсан тул тусгаарлалтын ажилд хөрөнгө гаргасугай.


2. Ус тусгаарлалтын ажилд шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг хавсралтаар баталж, холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (П.Баттүшиг)-т зөвшөөрсүгэй.

3. Уг ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Дэмчигжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Багануур дүүргийн Засаг даргын 2023
оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



Эрүүл мэндийн төвийн цахилгаан шатны ус тусгаарлалтын
ажилд шаардагдах зардлын төсөв

№	Материалын нэр	ТИП марк, тайлбар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (төгрөг)
1	ПП-1 анкер	Шавхагчийн хавхлаг	ш	60	9,000	540,000
2	Hansa Cryl PU101	Ус тусгаарлагч бодис	кг	70	76,800	5,376,000
3	Кингконг чигжээс	Түргэн бэхждэг усны бөглөө	кг	60	18,500	1,110,000
4	B18 EU2000	Шингэн мембран	кг	40	24,350	974,000
Нийт дүн						8,000,000